



ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 13/12

Эрдэнэт


Хувь хэмжээг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухайн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, Монгол Ардын намын бүлгийн 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 221, Ардчилсан намын бүлгийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Хүсэлт хүргүүлэх тухай” 258 дугаар албан бичгүүдээр ирүүлсэн саналуудыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэг төлөөлөгчийн суудалд олгох санхүүгийн дэмжлэгийг 20,000,000 (хорин сая) төгрөгөөр тогтоож шинэчлэн баталсугай.

2. Санхүүгийн дэмжлэгийг жил бүрийн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын төсөвт тусган батлуулж байхыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Д.Мөнхбат)-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХБАТ